



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж,
үйлчилгээний зардлын даатгалын сангаас төлөх төлбөрийн
дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчид үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-д зааснаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаарыг 2 000 000 /хоёр сая/ төгрөгөөр шинэчлэн тогтоож, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан төлбөрийн дээд хязгаарыг баримтлан ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Уртнасан/-т даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /М.Саранчимэг/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 15 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ